

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2012 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

Нэг. “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах” дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Хөтөлбөрийн хүрээнд оролцогч банктай гэрээ байгуулан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавихыг Монголбанкны Валют, эдийн засгийн газар /Д.Дэлгэрсайхан/-г, гүйцэтгэгч хуулийн этгээдтэй гэрээ байгуулан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавихыг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Батзаяа/-д тус тус үүрэг болгосугай.

Гурав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг улирал тутам Монголбанкны Захирлуудын зөвлөл, Зам, тээврийн яамны Сайдын зөвлөлд тус тус танилцуулахыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын алба /Д.Ган-Очир/, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ё.Манлайбаяр/-г тус тус даалгасугай.

Н. ЗОЛЖАРГАЛ
МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

А. ГАНСҮХ
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

**“ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ ИМПОРТЫН БАРАА,
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТГИЙГ БУУРУУЛАХ (TLF)”
ДЭД ХӨТӨЛБӨР**

Нэг. Зорилго

“Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах” дэд хөтөлбөр /цаашид TLFдэд хөтөлбөр гэх/-ийн зорилго нь гадаад худалдааны тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулах замаар өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн жигд тасралтгүй байдлыг хангах, үнийн өсөлтийг хязгаарлахад оршино.

Хоёр. Хэрэгжүүлэх зарчим

TLF дэдхөтөлбөрийг дараах зарчмаар хэрэгжүүлнэ:

- Дэд хөтөлбөр нь өргөн хэрэглээний барааны тээвэр, логистикт богино хугацаанд тулгарч буй хүндрэлийг шийдэхэд чиглэх;
- Дэд хөтөлбөрт Хөгжлийн банкнаас санхүүжигдэх Засгийн газрын урт хугацааны төсөл, хөтөлбөрийг хамруулахгүй байх.

Гурав. Зорилт, арга хэмжээ, үр дүн

TLF дэд хөтөлбөрийн хүрээнд дараах үндсэн зорилтыг хэрэгжүүлнэ:

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүн	Зээлийн шугамын дүн	Хэрэгжүүлэх хугацаа
1	Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний ачаа эргэлтийг нэмэгдүүлж, хурдасгана. (ЗҮ-УБ чиглэл)	Тусгай зориулалтын 2 галт тэргийг хатуу зурмагаар аялуулах.	Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлтэд зориулан өдөрт 100-с доошгүй вагоноор хангаж, 9000 тонн ачааг ЗҮ-УБ хооронд 24 цагийн дотор тээвэрлэх.	-	Хөтөлбөр батлагдсан өдрөөс
		Сэлгээний ажил болон ачаа ачиж, буулгах үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулан хурдасгах.			
		Шинэ жил, цагаан сарын баяр зэрэг улирлын чанартай ачааллыг бууруулахад чиглэсэн тусгайлсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Ачааллыг зохицуулсан тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх.		
2.	Ачаа тээвэрлэлтийн өртгийг бууруулна.	Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн өртгийг бууруулах.	Ачаа тээвэрлэлтийн өртөг буурсан байх.	-	2012 оны 4-р улиралд
		Монгол-Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийн шатахууны эргэлтийн хөрөнгөд зориулан зээлийн шугам нээх.	Шатахууны зардал 17% хүртэл буурах.	22 хүртэл тэрбум төгрөг	Хөтөлбөр батлагдсан өдрөөс үе шаттайгаар

		Тарифын бус зардлыг бууруулахад чиглэсэн зохион байгуулалт, хяналтыг сайжруулах.	Холбогдох байгууллагуудтай хамтран арга хэмжээ авсан байх.	-	Хөтөлбөр батлагдсан өдрөөс
3.	Тяньжин-Замын-Үүд чиглэлийн ачаа тээвэрлэлтийг хөнгөвчилнө.	Тяньжин боомтын шилжүүлэн ачилт болон бусад үйл ажиллагааг хурдасгах. Ачаа тээвэрлэлтийн хугацааг багасгах.	Зам, тээврийн яамнаас холбогдох арга хэмжээг авсан байх.	-	Хөтөлбөр батлагдсан өдрөөс
4.	Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлнэ.	Төмөр замын салбарын ачааны вагон паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.	1000 вагоноор нэмэгдсэн байх.	136 хүртэл тэрбум төгрөг	Хөтөлбөр батлагдсан өдрөөс хойш үе шаттайгаар
		Монгол-Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийн зүтгүүрийн паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.	20 зүтгүүрээр нэмэгдсэн байх.	95 хүртэл тэрбум төгрөг	
5	Ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	<ul style="list-style-type: none"> Замын-Үүд боомтын төмөр зам, авто замын ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлэх; Улаанбаатар хот дахь ачааны терминалын ачаа боловсруулах чадварыг нэмэгдүүлэх. 	<ul style="list-style-type: none"> ТЭЗҮ-г боловсруулж, батлуулсан байх. Улаанбаатар, Замын-Үүдийн төмөр зам, авто замын ачаа тээврийн нэгдсэн терминалыг батлагдсан ТЭЗҮ-ийн дагуу өргөтгөсөн байх; Замын-Үүдийн Улсын хилийг терминал 3-тай холбосон автозамыг ашиглалтад оруулсан байх. 	-	2012 оны 4-р улиралд
			50 хүртэл тэрбум төгрөг	ТЭЗҮ батлагдсаны дараа	

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

4.1 TLF дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих, уялдуулан зохицуулах чиг үүргийг Монголбанк, Зам, тээврийн яам хамтран хэрэгжүүлнэ.

4.2 Монголбанк дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 4.2.1 TLF дэд хөтөлбөрийн зорилт, арга хэмжээнд нэмэлт өөрчлөлт оруулах, дуусгавар болгох, үргэлжлүүлэх асуудлыг Зам, тээврийн яамтай хамтран шийдвэрлэх;
- 4.2.2 TLF дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон мэдээ, мэдээлэл, тайлбарыг Зам, тээврийн яамнаас гаргуулан авах;
- 4.2.3 TLF дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Зам, тээврийн яаманд хүргүүлсэн саналд ажлын 10 хоногийн дотор хариу өгөөгүй тохиолдолд Монголбанкны саналыг дэмжсэнд тооцож, хэрэгжилтийг хангуулах;
- 4.2.4 TLF дэд хөтөлбөрт зориулан хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн шугамыг банкаар дамжуулан гүйцэтгэгч хуулийн этгээдэд нээх;
- 4.2.5 TLF дэд хөтөлбөртэй холбоотой мэдээ, мэдээллийг Зам, тээврийн яаманд хүргүүлж байх;
- 4.2.6 Шаардлагатай тохиолдолд Зам, тээврийн яамтай хамтран болон бие дааж TLF дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хэсэгчилсэн шалгалтыг явуулах;

4.2.7 TLF дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг Зам, тээврийн яамтай хамтран улирал тутам гаргаж, нийтэд мэдээлэх.

4.3 Зам, тээврийн яам дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.3.1 TLF дэд хөтөлбөрийн зорилт, арга хэмжээнд нэмэлт өөрчлөлт оруулах, дуусгавар болгох, үргэлжлүүлэх асуудлыг Монголбанктай хамтран шийдвэрлэх;

4.3.2 TLF дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон мэдээ, мэдээлэл, тайлбарыг Монголбанкнаас гаргуулан авах;

4.3.3 TLF дэд хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэгч хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, гэрээний биелэлтэд хяналт тавих;

4.3.4 TLF дэд хөтөлбөрийн хэрэгжилттэй уялдан өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний төмөр замын тээвэрлэлтийн тарифыг бууруулах;

4.3.5 Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүнийг тээвэрлэх галт тэргийг хатуу зурмагаар аялуулах, сэлгээний ажил болон ачаа ачиж, буулгах үйл ажиллагааг хөнгөвчлөх, түргэн шуурхай явуулах асуудлыг тусгай журмаар зохицуулах;

4.3.6 Шинэ жил, цагаан сарын баяр, улирлын чанартай ачааллыг бууруулахад чиглэсэн тусгайлсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

4.3.7 TLF дэд хөтөлбөрийн зорилго, хэрэгжилтийг олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах;

4.3.8 TLF дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд нөлөөлөхүйц бодлогын шийдвэр гаргахдаа Монголбанктай зөвшилцөх;

4.3.9 TLF дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах;

4.3.10 TLF дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үрдүнг Монголбанктай хамтран улирал тутам нийтэд мэдээлэх;

4.3.11 TLF дэд хөтөлбөртэй холбоотой худалдан авалтаас үл хамааран энэхүү хөтөлбөрийн зорилтуудын хэрэгжилтийг хангах.

Тав. Хэрэгжүүлэх хугацаа, зээлийн шугам

5.1 TLF дэд хөтөлбөр нь **3 жил**хүртэл хугацаанд хэрэгжинэ.

5.2 TLF дэд хөтөлбөрийн нийт зээлийн шугам нь **303 хүртэл тэрбум төгрөг /гурван зуун гурав хүртэл тэрбум төгрөг/** бөгөөд дараах төслүүдэд зориулан зээлийн шугам нээнэ:

Д/д	Төслийн нэр	Ш аардлагатай төсөв
1	Вагоны паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	136.0
2	Зүтгүүрийн паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	95.0
3	Шатахууны эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх	22.0
4	Ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлэх	50.0
Нийт дүн		303.0

Хүснэгт 1. TLF дэд хөтөлбөрийн зээлийн шугамын хэмжээ, төслүүдээр/тэрбум төгрөгөөр/

5.3 Зээлийн хүүг Монголбанкнаас тогтоосон хүүн дээр оролцогч банкны хүүний маржины дээд хязгаарыг нэмж тооцно. Монголбанкнаас тогтоосон хүү нь зөвхөн энэ дэд хөтөлбөрт зориулж үнийн тогтвортой байдлыг харгалзан сар тутам тооцсон хүү байна.

“Өргөн хэрэглээний импортын бараа,
бүтээгдэхүүний өртгийг бууруулах (TLF)”
дэд хөтөлбөрийн хавсралт

TLF дэд хөтөлбөрийн төсвийн задаргаа
/Төсөл тус бүрээр/

1. Вагоны паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх

/сая төгрөгөөр/

Д/д	Вагоны төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт
1	Хагас вагон	600	118	70,658
2	Тавцанг вагон	150	122	18,354
3	Битүү вагон	200	143	28,674
4	Цистерн	30	192	5,773
5	Тогтмол дулаанг	20	613	12,270
Нийт дүн		1000		135,729

2. Зүтгүүрийн паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх

Зээлийн шугамын нийт дүн **95 хүртэл тэрбум төгрөг** байна. /Нэг бүрийг 4.7 тэрбум төгрөгөөр 20 зүтгүүр/

3. Шатахууны эргэлтийн хөрөнгөд зориулсан зээлийн шугам нээх

Зээлийн шугамын нийт дүн УБТЗ-ын 2 сарын шатахууны хэрэглээтэй тэнцүү буюу **22 хүртэл тэрбум төгрөг** байна.

4. Ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлэх

Зээлийн шугамын нийт дүн **50 хүртэл тэрбум төгрөг** байна.

---oOo---